



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум,

Утас: 70272248, Факс: 70272582

И мэйл: tuv@audit.gov.mn

2022.05.11 № 01/314  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ**

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Үндэсний Аудитын Газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг цахим хэлбэрээр хүргүүлж байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

**19030709**

D 2022 /2022 он/ALBANBICHIG

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨАГ-2022/16-18-ШТА-ТД

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)  
Аудитын менежер О.Амаржаргал  
Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)  
Ахлах аудитор Л.Жаргалсайхан  
Утас: 70273465 Цахим хаяг: [jargalsaikhanl@audit.gov.mn](mailto:jargalsaikhanl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

**АГУУЛГА**

|                                                                             |   |
|-----------------------------------------------------------------------------|---|
| Товчилсон үгийн тайлбар.....                                                | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл ..... | 4 |

**А.1 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн ажлуудад иргэд, олон нийтийн санал авах тогтолцоо бүрдээгүй байна.**

**А.1.1 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдаж байгаа хэдий ч богино хугацааны баримт бичиг буюу тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаадаагүй арга хэмжээнүүд батлагдаж байна.....**6

**А.1.2 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр батлагдсан төсөл арга хэмжээний дийлэнх нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.....**7

**А.1.3 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ажлуудад иргэд, олон нийтийн санал авах тогтолцоо байхгүй байна .....**8

**А.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 44 ажил хийхээр төлөвлөснөөс, 41 арга хэмжээ хэрэгжсэн байна.**

**А.2.1. Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдсэн барилгын нэг ажлын хувьд төсөвлөлтийн шаардлагыг хангасан байна.....**8

**А.2.2 Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтойгоор санхүүжилт батлагдсан байна.....**8

**А.2.3 Аймгийн шилжих үлдэгдлээр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалтад хөрөнгө оруулалтын чанартай барилгын ажил 1, их засварын 2 ажил батлагдсан байна.....**9

**Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хэрэгжүүлэхдээ батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлахгүй байна**

**Б.1.1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх нэг ажлын хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээний хороо байгуулахаар заасан хугацаанаас хойш эрх шилжүүлэх захирамж гарчээ.....**10

**Б.1.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудаас нэгээс бусад ажлын хувьд тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.....**11

**Б.1.3. Шинэ хөдөө хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тендерт тендерийн бичиг баримтад тусгагдсан шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна.....**12

**Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна. ....**14

**Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулж ажилласан хэдий ч ихэнх ажил гэрээнд заасан хугацаанаас хоцорч ашиглалтад орж байна.**

**Б.2.1. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудын дийлэнх нь гэрээнд заасан хугацаанаас хэтэрч ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.....**15

**Б.2.2. Аймгийн Засаг даргын захирамжаар захиалагч томилж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.....**15

**Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар ямар нэг зөрчил илрүүлээгүй байна.....**17

**Б.3 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрэн олгосон байна.**

**Б.3.1. Үе шатны ажлын гүйцэтгэлийг захиалагч хянаж, баталгаажуулан санхүүжилтийн мэдээгдэл өгч санхүүжилт олгосон байна.....**18

**Б.3.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудыг ашиглалтад хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгах ажил бүрэн хийгдээгүй байна.....** 19

**Б.4 Нийт 4 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.**

|                                                           |    |
|-----------------------------------------------------------|----|
| <b>ДҮГНЭЛТ:</b> .....                                     | 20 |
| <b>ЗӨВЛӨМЖ:</b> .....                                     | 21 |
| <b>Холбогдох байгууллагын санал:</b> .....                | 22 |
| <b>Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:</b> ..... | 29 |

#### Товчилсон үгийн тайлбар

|              |                                                                                  |
|--------------|----------------------------------------------------------------------------------|
| АДБОУС       | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт                                    |
| АЗЗА         | Авто зам засвар арчлалт                                                          |
| БЗОСК        | Барилга захиалагч, орон сууцны корпораци                                         |
| БОАЖГ        | Байгаль орчин аялал жуулчлалын газар                                             |
| ГХБХБГ       | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар                                   |
| ДЭХГ         | Дулааны эрчим хүчний газар                                                       |
| ИТХ          | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                                     |
| ЗДТГ         | Засаг даргын тамгын газар                                                        |
| НАГ          | Нийслэлийн аудитын газар                                                         |
| ОНӨААТҮГ     | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                             |
| ОНӨГ         | Орон нутгийн өмчийн газар                                                        |
| ОНХС         | Орон нутгийн хөгжлийн сан                                                        |
| СТСХ         | Санхүү төрийн сангийн хэлтэс                                                     |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| ТӨӨЗ         | Тендерт оролцогчид өгөх зөвлөмж                                                  |
| ТӨААТҮГ      | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                   |
| ТӨХК         | Төрийн өмчийн хувьцаат компани                                                   |
| ТШӨХ         | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт                                          |
| ТЭЗҮ         | Техник эдийн засгийн үндэслэл                                                    |
| ХОХБТХ       | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс                            |
| ХХААГ        | Хүнс хөдөө аж ахуйн газар                                                        |
| ХХК          | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                             |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

**Аудитын зорилт**

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн эсэх.

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

**Аудитын хязгаарлалт**

Байхгүй.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”,
- MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”,
- MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”,
- MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Барилга, байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт

- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр хийж гүйцэтгэн НАГ-т хүргүүлээ.

**Хүндрэл бэрхшээл**

## БҮЛЭГ А.

**А.1 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн ажлуудад иргэд, олон нийтийн санал авах тогтолцоо бүрдээгүй байна.**

*А.1.1 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдаж байгаа хэдий ч богино хугацааны баримт бичиг буюу тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээнүүд батлагдаж байна.*

Аймгийн Засаг дарга Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10–д заасны дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдийг боловсруулан аймгийн ИТХ-д өргөн барьсан байна. Аймгийн ИТХ дээрх хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1–д заасны дагуу баримт бичгүүдийг хэлэлцэн, 2020 оны 11 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 02 дугаар тогтоолоор “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-н 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсөв батлахад аймгийн ОНХС-н эх үүсвэрээр 7,225.2 сая төгрөгийн 56 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, орон нутгийн шилжих үлдэгдлээр 3,500.0 сая төгрөгийн 11 арга хэмжээ, замын сангийн эх үүсвэрээр 682.0 сая төгрөгийн 13 арга хэмжээ, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 752.5 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ нийт 12,159.7 сая төгрөгийн 100 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ОНХС-н үйл ажиллагаанд нэгдсэн төлөвлөгөөгөөр гүйцэтгэлийн аудит хийгдэх тул энэ аудитаар орон нутгийн шилжих үлдэгдлээр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн арга хэмжээг авч үзсэн болно.

Шилжих үлдэгдлээр хийгдэх 11 арга хэмжээний 10 нь дээрх хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдсан, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 13 арга хэмжээ “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т ерөнхий утгаараа тусгагдсан бол байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжих 20 арга хэмжээний 10 нь “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д, 15 нь “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т, 17 нь “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.4-д Зам тээвэр, харилцаа холбоо гэсэн бүлгийн 201-д Батсүмбэр сумын Мандлын гүүрний шинэчлэлтийн ажлыг эхлүүлнэ, 202-д гүүрний ээлжит засварын ажлыг эрэмбийн дагуу хийнэ гэж заасан байхад гүүр засвартай холбоотой нэг ч ажил төлөвлөгдөөгүй. 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй Өндөрширээт сумын мэнгэтийн давааны засварын ажилд 20.0 сая төгрөг төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар монгол тарвага сэргээн нутагшуулах зардал /Баянцагаан сум/ 15.0 сая төгрөг, Бэлчээрийн худаг гаргах 108.0 сая төгрөг, хогийн сав байршуулах зардал 10.0 сая төгрөг зэрэг ажлууд 2021

оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 50 хувь буюу тал нь "Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт ..... аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвт хамаарна", 6.10.4-д "орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

*А.1.2 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр батлагдсан төсөл арга хэмжээний дийлэнх нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдэхээр төлөвлөсөн 11 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнээс барилгын ажил 1, их засварын ажил 2 байна. Бүрэн сумын ЗДТГ-н барилга 1969 онд ашиглалтад орсон, мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр ашиглах боломжгүй болсон тул 2020, 2021 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж ашиглалтад оруулсан. Их засварын ажлууд нь төрийн албан хаагчийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах, төрийн байгууллагаас үйлчилгээ авч буй иргэдийн аюулгүй байдал, тав тухыг хангах, эмнэлгийн орчин, стандарт, хэвтэн эмчлүүлж буй иргэдийн хэрэгцээ шаардлага зэрэгт үндэслэгдсэн байна. Дээрх эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ нь бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зах зээлийн үнээс бага зардлаар орон сууц түрээсэлж, амьдралын нөхцөлөө сайжруулах, бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэл үйлчилгээг бага хүүтэй зээлийн бодлогоор дэмжих, малчин өрх, газар тариалан эрхлэгч, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн бэлтгэл ажлыг хангах зэрэг хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ нь авто замын ашиглалтын бэлэн байдлын үзлэг, авто зам, гүүрний арчлалт, засварын ажлын норм зэрэгт үндэслэж төлөвлөгджээ. Авто замын эвдрэл гэмтэл нь иргэд, зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд сөргөөр нөлөөлдөг тул хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаар үндэслэгдсэн байна. Мөн сумын ЗДТГ, аймгийн замын цагдаагийн тасгаас санал ирүүлсэн саналын дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зарим ажлууд чиглэгджээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20 арга хэмжээнээс 10 арга хэмжээ нь доорх хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.

- Аймгийн аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хугацаа дууссан. Цаашид аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж сэргээх, шинэ төрлийн аяллын чиглэл, төрлийг нэмэгдүүлэн жуулчдыг татаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагад үндэслэн дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулах шаардлагатай.
- Олон улсын нисэх буудал Төв аймагт байгуулагдсантай холбоотойгоор Монголд зорин ирж буй жуулчдыг хамгийн түрүүнд мэдээллээр хангаж, Төв аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулж, сурталчлах зорилготой.
- Аймгийн хэмжээнд 57 рашаан, рашаан төст булаг байдаг бөгөөд ард иргэд эрүүл мэндэд сайн хэмээн хэрэглэдэг тул тухайн рашааны найрлагыг нарийвчлан судалж, ямар эд эрхтэнд сайн болох, хэрэглэх аргыг шинжлэх

ухаанд үндэслэн гаргаж ирэхийн тулд судалгааны ажлыг хийж, ард иргэдийг мэдээллээр хангах шаардлага байдаг.

- Ард иргэдийг эрүүл, аюулгүй ундны усаар тасралтгүй хангах зорилтын хүрээнд усны худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг 2016 оноос хойш шат дараалан хэрэгжүүлж байна.
- Усны тухай хуулийн 12, 17-р зүйлийг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн төлбөр тооцох, ашиглалтад хяналт тавих зорилгоор тооллогын ажлыг зохион байгуулдаг.
- Төв суурин газрын ундны усны чанарын судалгаа хийж, мэдээллийн сан байгуулах, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах нэн тэргүүний хэрэгцээ болох эрүүл, аюулгүй ундны усаар хангах ажлын хүрээнд судалгаа шинжилгээ хийгдэх шаардлага бий. Төв аймгийн хувьд ундны усанд химийн болон нянгийн шинжилгээг тогтмол хийж хэвшиж байгаа ч хүнд металл, изотопын шинжилгээг аймгийн хэмжээнд хийж байгаагүй байна
- Хог хаягдлыг ангилан ялгах, шатаах, ландфилл байгуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийлгүүлэх ажил нь аймгийн ИТХ-ын 2017 оны 08 дугаар сарын 10 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 93 дугаар тогтоолоор дэмжигдсэн тул үргэлжлүүлэх шаардлагатай.

Бусад 10 арга хэмжээ нь аймгийн БОАЖГ-ын саналаар төлөвлөгдөж батлагдсан байна.

*А.1.3 Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ажлуудад иргэд, олон нийтийн санал авах тогтолцоо байхгүй байна.*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2-д “төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах” зарчим баримлахаар заасан. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн ажлуудад сумдын ИТХ, Засаг даргын болон холбогдох байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг харгалзахаас бус иргэд, олон нийтийн санал авах талаар бодитой ажил хийгдээгүй байна.

Замын сангийн тухайд Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5, 24.5, 24.7, 24.8, 24.9-д заасан болон Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-аар зохицуулагддаг тул төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог хангахад хязгаарлагдмал байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу төлөвлөгдөж байна.

**А.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 44 ажил хийхээр төлөвлөснөөс, 41 арга хэмжээ хэрэгжсэн байна.**

*А.2.1. Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдсэн барилгын нэг ажлын хувьд төсөвлөлтийн шаардлагыг хангасан байна.*

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан

бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан. Аймгийн шилжих үлдэгдлээр 2021 онд хийгдсэн ажлуудаас Бүрэн сумын ЗДТГ-н барилгын ажлаас /2020 оноос дамжсан/ бусад ажлуудад дээрх шаардлага хамаарахааргүй байна. Тус эх үүсвэрээр батлагдсан бусад ажлууд нь их засварын ажил, хөтөлбөр төслүүд байна. Бүрэн сумын ЗДТГ-н барилгын тухайд зураг төсөл нь 2019 онд хийгдэж магадлалын дүгнэлтээр баталгаажсан, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд нь хууль, журмын дагуу хийгдсэн байна.

Замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлууд нь авто замын засвар, арчлалт, тэмдэгжүүлэх, зураг төсөл боловсруулах, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхэд чиглэгдсэн ажлууд батлагдсан байна

*А.2.2 Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтойгоор санхүүжилт батлагдсан байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдэхээр төлөвлөсөн 11 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнээс 3 арга хэмжээнээс бусад нь хэрэгжсэн байна. Хэрэгжээгүй 3 арга хэмжээ нь Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх 800.0 сая төгрөг, Аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөл 80.0 сая төгрөг, Шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөл 90.0 сая төгрөгийн ажил байна. Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх буюу орон сууц худалдан авч түрээслэх ажил нь 2021 онд шинээр орон сууц ашиглалтад ороогүй, тендерт гүйцэтгэгч оролцоогүйтэй холбоотойгоор, зураг төслийн ажлууд нь гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлаа хүлээлгэж өгөөгүйтэй холбоотойгоор тус тус хэрэгжээгүй байна. Замын сангаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 13 ажлаас 1-с бусад ажил хэрэгжсэн. Өндөрширээт сумын мэнгэтийн давааг засварлах ажил тус замыг хариуцагч Эрдэнэсант АЗЗА ТӨХК гэрээ байгуулаагүйгээс хийгдээгүй байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 20 ажил хийхээр төлөвлөснөөс Заамар суманд эвдэрсэн газар нөхөн сэргээх ажлаас бусад ажлууд хийгдсэн.

Хийгдээгүй ажлуудын санхүүжилт нь батлагдсан байсан бөгөөд аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх ажлын 72.0 сая төгрөг, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх ажлын 44.9 сая төгрөгийг барьцаа санд төвлөрүүлсэн байна. 2021 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийн хувьд хугацаандаа хэрэгжих боломжтойгоор санхүүжилт нь батлагдсан байна.

*А.2.3 Аймгийн шилжих үлдэгдлээр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалтад хөрөнгө оруулалтын чанартай барилгын ажил 1, их засварын 2 ажил батлагдсан байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдэх ажлуудаас хөрөнгө оруулалтын чанартай барилгын ажил 1, их засварын ажил 2, бусад нь хөтөлбөр төсөл арга хэмжээ байна. Хөтөлбөр төсөл арга хэмжээнүүдээс хөрөнгө оруулалтын чанартай биш аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт хөрөнгө төвлөрүүлэх, ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, “Мон” төслийн зээлийн төлбөр төлөх зэрэг 1,498.7 сая төгрөгийн арга хэмжээнүүд батлагдсан байна.

| № | Төсөл арга хэмжээ                                                                               | Батлагдсан төсөвт өртөг сая,төг | 2021 онд санхүүжих дүн сая,төг |
|---|-------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|--------------------------------|
| 1 | Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт хөрөнгө төвлөрүүлэх                                          | 1,000.0                         | 1,000.0                        |
| 2 | Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардал | 48.7                            | 48.7                           |
| 3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх                                        | 370.0                           | 370.0                          |
| 4 | Мон төслийн зээлийн төлбөр төлөх                                                                | 80.0                            | 80.0                           |
|   | Дүн                                                                                             | 1,498.7                         | 1,498.7                        |

Эх сурвалж: Төв аймгийн төсөв баталсан 2020.12.03-ны өдрийн 03 тогтоол

Мөн Засгийн Газрын шинэ хөдөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал гэж 510.0 сая төгрөг ерөнхий нэрээр батлагдсан нь 50.2 сая төгрөгөөр сумдад төлгөн хурган хуц тараах, Сэлэнгэ, Герефорд үхрийн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, 425.0 сая төгрөгөөр нэг бүр нь 12.5 сая төгрөгийн үнэтэй 34 толгой “Монбелиард” үүлдрийн үхэр худалдан авч иргэд, хоршоодод эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох ажил болж хэрэгжсэн.

Замын сангаар авто зам засвар, арчлалт, зураг төсөл боловсруулах зэрэг 13 ажил батлагдсан. Авто замын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлагдсан Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журмын дагуу орон нутгийн чанартай авто замын хураамж төвлөрүүлэх зардалд 3.0 сая төгрөг батлагдсан.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 20 ажил хийхээр төлөвлөснөөс нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах зардал, байгаль орчны салбарын албан хаагчдыг чадавхжуулах нэгдсэн сургалт, семинар зохион байгуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардал, байгаль орчны чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, бодлого хөтөлбөрүүдийн хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулах зардал зэрэг 60.5 сая төгрөгийн үйл ажиллагааны урсгал зардал батлагджээ.

## БҮЛЭГ Б.

**Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хэрэгжүүлэхдээ батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлахгүй байна.**

*Б.1.1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх нэг ажлын хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээний хороо байгуулахаар заасан хугацаанаас хойш эрх шилжүүлэх захирамж гарчээ*

Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудаас 2 ажлыг сумын Засаг даргад эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна. Замын сангийн хөрөнгөөр хийгдэх Хэрлэн гол дээр бирваз засварын ажлыг /40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/28 тоот захирамжаар Мөнгөнморьт сумын Засаг даргад, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ойгоос мод шилжүүлэн суулгах замаар аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг сайжруулах ажлыг /130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/137 тоот захирамжаар Зуунмод сумын Засаг даргад тус тус эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн.

Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/60 тоот захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж 2021 оны 04 дүгээр сарын 21, 5 дугаар сарын 25-нд хоёр удаа цахимаар тендер зарлахад оролцогч санал ирүүлээгүй тул хэлэлцээрийн урилга хүргүүлж Мөнх дөлгөөн тулга ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Зуунмод сумын Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/199 тоот захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж, 4 дүгээр сарын 19-нд тендер зарлаж, 6 дугаар сарын 15-нд тендерт шалгарсан Монгол тохь ХХК-тай гэрээ байгуулсан гүйцэтгүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хэрлэн гол дээр бирваз засварын ажлын үнэлгээний хороо байгуулах хугацаа 2021 оны 02 дугаар сарын 23 гэж заасан, эрх шилжүүлэх захирамж 2021 оны 01 дүгээр сарын 20-нд гарсан нь худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлэх боломжтой байхаар эрх шилжүүлжээ. Харин ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ойгоос мод шилжүүлэн суулгах замаар аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг сайжруулах ажлын үнэлгээний хороо байгуулах хугацаа төлөвлөгөөнд 2021 оны 02 дугаар сарын 05-нд байхад эрх шилжүүлэх захирамж 2021 оны 3 дугаар сарын 02-нд гарсан байна. Үүнээс шалтгаалж энэ ажлын хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас үнэлгээний хороо байгуулах ажил 66, тендер зарлах ажил 71, гэрээ байгуулах эрх олгох ажил 99 хоногоор хэтэрч хийгджээ.

Хэдийгээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацааг мөрдөгдөөгүй боловч тендер шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тайлант ондоо эдгээр ажлууд хийгдэж дууссан байна.

*Б.1.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудаас нэгээс бусад ажлын хувьд тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.*

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/607 тоот захирамжаар аймгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл бэлэн болгох гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий захиалагчийг томилсон. 2021 онд 2 удаагийн захирамжаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт оруулсан.

Аймгийн шилжих үлдэгдлээр тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 4-н ажил байна. Эдгээр ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаатай харьцуулж үзэхэд 1 ажил төлөвлөгөөнд тусгагдсан хугацаандаа, бусад 3-н ажлын хувьд үнэлгээний хороо байгуулах ажил 45-207 хоног, тендер зарлах хугацаа 49-240 хоног, гэрээ байгуулах эрх олгох хугацаа 160-264 хоногоор төлөвлөснөөс хоцорч хэрэгжсэн байна. Худалдан авах ажиллагааг төлөвлөсний дагуу зохион байгуулаагүйгээс болж дээрх 4-н ажлаас аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв гэсэн 2 ажил тайлант онд дуусаагүй он дамжин хэрэгжиж байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 6-н ажлыг тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эдгээр ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаатай харьцуулж үзэхэд 4 ажил төлөвлөгөөнд тусгагдсан

хугацаандаа, үлдсэн 2 ажлын хувьд үнэлгээний хороо байгуулах ажил 49-55 хоног, тендер зарлах хугацаа 49-57 хоног, гэрээ байгуулах эрх олгох хугацаа 36-178 хоногоор төлөвлөснөөс хоцорч хэрэгжсэн. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудаас худалдан авах ажиллагаанаас шалтгаалж хэрэгжээгүй буюу дутуу хэрэгжсэн ажил байхгүй байна

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 12 ажлыг тендер зарлан гүйцэтгүүлсэн. Эдгээр ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаатай харьцуулж үзэхэд үнэлгээний хороо байгуулах ажил 35-104 хоног, тендер зарлах хугацаа 42-126 хоног, гэрээ байгуулах эрх олгох хугацаа 40-193 хоногоор төлөвлөснөөс хоцорч хэрэгжсэн. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төлөвлөгөөнд заасан хугацаа мөрдөгдөөгүй хэдийн ч үүнээс шалтгаалж хэрэгжээгүй буюу дутуу хэрэгжсэн ажил гараагүй байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад оролцогч санал ирүүлээгүй байх, ирүүлсэн санал нь шаардлага хангахгүй зэргээс шалтгаалан тендерийг дахин дахин зарлах, шууд гэрээний урилгыг цахимаар хүргүүлж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж байгаагаас шалтгаалж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гэрээ байгуулах эрх олгохоор төлөвлөсөн хугацаа мөрдөх боломжгүй болдог байна. Үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах хугацааг боломжтой байдлаар төлөвлөж мөрдөж байх шаардлагатай байна.

Аймгийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хийгдэх аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх ажлын худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулж гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 11-нд байгуулснаас болж тайлант онд хэрэгжих боломжгүй болсон байна. Бусад ажлуудын хувьд худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжтойгоор зохион байгуулжээ.

*Б.1.3. Шинэ хөдөө хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тендерт тендерийн бичиг баримтад тусгагдсан шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна.*

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн шилжих үлдэгдлээр хэрэгжүүлэх 9 арга хэмжээний 5 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 1 ажлыг харьцуулалтын аргаар, 3 ажлыг шууд гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх ажил хийгдээгүй үлдсэн 4 ажил нээлттэй тендер шалгаруулалтаар, 1 ажил харьцуулалтын аргаар, 3 ажил шууд гэрээгээр хийгдсэн.

Шилжих үлдэгдлээр хийгдэх Засгийн газрын шинэ хөдөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал гэж 510.0 сая төгрөг батлагдсан. Үүнээс 425.0 сая төгрөгөөр "Монбелиард" үүлдрийн үхэр нийлүүлэх тендер 2021 оны 10 дугаар сарын 12-нд зарлаж 2021 оны 11 дүгээр сарын 12-нд Нүүдэлчин агро ферм ХХК -г шалгаруулсан. Тендерийн баримт бичгийн Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТӨӨЗ 12.1(ё)-н 3-д "компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг цахим системээс авч ирүүлнэ", ТШӨХ заасан аль нэг баримтыг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно гэж заасан. Гэтэл шалгарсан Нүүдэлчин агро ферм ХХК шүүхийн архивын тодорхойлолт ирүүлээгүй байна. Мөн ТӨӨЗ 18.2(д)-д "тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2018, 2019, 2020 онуудад ашигтай ажилласан байх бөгөөд тус шаардлагыг хангаагүй нөхцөлд оролцогчийн тендерээс татгалзана" гэж заасан. Гэтэл тус компани нь сүүлийн 3 жилд ашиггүй алдагдалтай ажилласан байхад шалгаруулжээ. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ",

27.1.1-д “энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага”, 27.1.2-д “техникийн тодорхойлолт”, 27.1.3-д “тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага”, 27.4-д “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэснийг тус тус зөрчсөн байна. Энэ ажлын үнэлгээний хороонд ажилласан ОНӨГ-н холбогдох мэргэжилтнүүд тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани улсын хэмжээнд ганцхан байдаг учраас оролцогч хязгаарлагдмал гэсэн үндэслэлээр шалгаруулсан гэсэн тайлбар ирүүлсэн.

Замын сангаар хийгдэх 12 ажлаас 6 ажил нээлттэй тендер шалгаруулалт, 3 ажил харьцуулалтын арга 3 ажил шууд худалдан авалтаар хийгдэхээр төлөвлөгдсөн. 4 ажил нээлттэй тендер шалгаруулалтаар 2 ажил харьцуулалтын аргаар, 4 ажил шууд гэрээгээр хийгдэж 2 ажил хийгдээгүй. Харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх Мэнгэтийн давааны засварын ажил, шууд гэрээгээр гүйцэтгэх байгалийн болзошгүй гамшиг, цас зудын үед орон нутгийн зам, давааг арчлах, сэргээн засварлах ажил хийгдээгүй.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд харьцуулалтын аргаар хийгдэхээр төлөвлөгдсөн Зуунмод сумын хатуу хучилттай авто замын засварын ажил /79.9 сая төгрөг/, Зуунмод сумын авто замын өвөл зуны арчлалтын ажил /79.3 сая төгрөг/ гэсэн 2 ажлыг шууд гэрээгээр Төв АЗЗА ТӨХК-р гүйцэтгүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэснийг зөрчсөн байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Зуунмод хотын төвийн авто замуудын дагуу явган хүний зам, хашлаганы засварын ажилд 4 удаа тендер зарлаад оролцогч санал ирүүлээгүй тул Ти Эн Жи Пи ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, *техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан* этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэж заасан. Хэлэлцээрийг цахимаар явуулсан бөгөөд цахим системд оруулсан тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад дээрх компанитай гэрээ байгуулсан. Тухайлбал: Тусгай зөвшөөрөл нь замын бус барилгынх, шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа байхгүй, мэргэжилтэй ажилчдын жагсаалтыг гаргаж мэргэжлийн үнэмлэхийг иргэний үнэмлэхийн хуулбарын хамт ирүүлнэ, машин, механизм, тоног төхөөрөмжийг санал болгож жагсаалтаар ирүүлнэ, техникийн гэрчилгээг ирүүлнэ гэсэн байхад ирүүлээгүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх 20 ажлаас зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар 2 ажил, 5 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 5 ажил харьцуулалтын аргаар тендер зарлан гүйцэтгүүлж 8 ажлыг шууд гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. Худалдан авах ажиллагааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудын худалдан авах ажиллагааны явцад Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д “тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх...” гэж заасан үүргийн дагуу

шаардлага хангаагүй тендерийн баримт бичгээр хянан үзэлгүй гүйцэтгэгчийг шалгаруулсан. Мөн захиалагч БЗОСК ОНӨААТҮГ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэснийг зөрчин 2 ажлыг шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Өмнөх жилүүдэд Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороод тендер шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд захиалагчид шууд гэрээ байгуулах дүгнэлт өгдөг байсан бол 2021 оны хувьд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д заасныг хэрэгжүүлж, цахим системээр урилга хүргүүлж гүйцэтгэгчтэй хэлэлцээр хийж шалгаруулдаг болсон байна.

*Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.*

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт, тайланг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж тайлагнасан байна.

2021 оны хагас жилийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын тайлангаас аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудыг авч үзэхэд үнэн зөв тайлагнасан байна.

Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” шинэчлэгдэн батлагдсаны дагуу 2021 оны жилийн эцсийн худалдан авах ажиллагааны тайланг гаргаж хүргүүлжээ. Жилийн эцсийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын тайлангаас аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудыг авч үзэхэд үнэн зөв тусгагдсан байна.

**Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулж ажилласан хэдий ч ихэнх ажил гэрээнд заасан хугацаанаас хоцорч ашиглалтад орж байна.**

*Б.2.1. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудын дийлэнх нь гэрээнд заасан хугацаанаас хэтэрч ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдэхээр батлагдсан ажлуудаас хөрөнгө оруулалтын чанартай биш Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт хөрөнгө төвлөрүүлэх, ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, “Мон” төслийн зээлийн төлбөр төлөх зэрэг ажлуудаас бусад ажлын хувьд захиалагч томилогдож гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. Гэрээ байгуулж 2021 онд дуусаж хүлээлгэн өгсөн ажлууд нь гэрээнд зааснаас 8-73 хоногоор хэтэрч ашиглалтад өгчээ.

Аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх ажлуудын захиалагчаар аймгийн ГХБХБГ томилогдон гэрээ байгуулж ажилласан эдгээр ажлуудыг гэрээний хугацаанд дуусган хүлээлгэж өгөөгүй. Аймгийн ЗДТГ-н өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах ажлыг Ти Эл Прожект ХХК-тай 72.0

сая төгрөгөөр 2022 оны 03 дугаар сарын 18-нд дуусгахаар гэрээ хийсэн боловч одоогоор хүлээлгэж өгөөгүй байна. Ашиглагч, захиалагчийн зүгээс шинээр барих барилгын хүчин чадал, давхар тоо нэмэх, дотор зохион байгуулалтыг эцэслэн шийдвэрлэх тал дээр хугацаа алдсанаас шалтгаалж зураг төслийн ажил хугацаандаа хийгдээгүй байна. Гүйцэтгэгчийн зүгээс гэрээний хугацаа сунгах хүсэлтийг тавьсан бөгөөд үүний дагуу нэмэлт гэрээ байгуулах, гэрээний хугацаанд өөрчлөлт оруулахаар болсон байна. Зуунмод сумын 1 дүгээр баг манзушир өргөө 1000 айлын орон сууцны хорооллын авто зам, явган зам, талбай, ногоон байгууламж, тоглоомын талбайн тохижилт, Зуунмод сумын 1 дүгээр багт шинэ дэд төвийн талбайн ажлын зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Инженер геодези ХХК-тай гэрээ байгуулан эхний 50 хувийн санхүүжилт 44.9 сая төгрөг олгосон боловч гэрээний хугацаа буюу 2021 оны 12 дугаар сарын 10-нд хүлээлгэн өгөөгүй. Захиалагчийн зүгээс зураг төслийн зургийн даалгаврыг боловсруулан өгч, боловсруулах явцад санал өгч, хугацаандаа хийж гүйцэтгэх талаар шаардлага тавьж ажиллаж байгаа гэсэн боловч аудит хийгдэж байх хугацаанд ажлаа дуусган хүлээлгэж өгөөгүй байна. Энэ хоёр ажилд гэрээнд заасны дагуу алданги тооцох ажлыг дуусган хүлээж авах албан шаардлага өгсөн.

Засгийн Газрын шинэ хөдөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 510.0 сая төгрөг батлагдсаныг хэрэгжүүлэх захиалагчаар аймгийн ХХААГ томилогдсон. Малын удмын сангийн үндэсний төвтэй шууд гэрээ байгуулан 6 суманд төлгөн, хурган хуц нийлүүлэх, 4 суманд зохиомол хээлтүүлэг хийх ажлыг хэрэгжүүлсэн. 425.0 сая төгрөгөөр монбелиард үүлдрийн үхэр худалдаж авах тендер зарлагдаж гүйцэтгэгчээр шалгарсан Нүүдэлчин агро ферм ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2022 оны 06 дугаар сард дуусах бөгөөд хүлээж авсан үхрийг төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр сонгогдсон хоршоодод олгоно. Хоршоод нь цэвэр үүлдрийн монбелиард үхэр худалдан авах чадавхтай, үйл ажиллагаа нь жигдэрсэн, дотоодын хэрэгцээнд мах, сүүгээ нийлүүлдэг зэрэг шаардлага хангасан байна гэсэн тайлбарын ХХААГ-ын холбогдох мэргэжилтнүүд өгч байгаа боловч одоогоор сонгон шалгаруулалтын бэлтгэл ажил эхлээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлуудаас 6 ажил нь гэрээний хугацаанд хэрэгжиж, бусад 6 ажил гэрээнд зааснаас 16-67 хоногоор хоцорч хүлээлгэн өгсөн байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн 20 ажлаас хөрөнгө оруулалтын чанартай бус 3 ажлаас бусад 17 ажлын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл 1 арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй, 4 ажил гэрээнд заасан хугацаанд, 12 ажил 6-118 хоногоор хэтэрч хэрэгжин хүлээлгэн өгсөн байна. Төв суурин газрын ундны усны чанарын судалгаа хийж, мэдээллийн сан байгуулах ажлыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй 2021 оны 9 дүгээр сарын 09-с 12 дугаар сарын 20-нд хооронд хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Тус судалгааны ажлыг танилцуулга сургалт хийгдэж байж албан ёсоор хүлээн авах тул тайлант онд багтаан хүлээж аваагүй байна.

2021 онд хийгдсэн ихэнх ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна.

#### ***Б.2.2. Аймгийн Засаг даргын захирамжаар захиалагч томилж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна***

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/607 тоот захирамжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл бэлэн болгох гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий захиалагчийг томилсон.

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдэх 8 ажилд дээрх захирамжаар захиалагч томилогдсон байна. БЗОСК ТӨААТҮГ 4 ажилд, аймгийн ХХААГ 1 ажилд, ГХБХБГ 2 ажилд, аймгийг ЗДТГ 1 ажилд тус тус захиалагчаар томилогдож тухайн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 11 ажилд БЗОСК ТӨААТҮГ, 1 ажилд Мөнгөнморьт сумын ЗДТГ захиалагчаар томилогдож хяналтыг хэрэгжүүлсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжсэн 17 ажилд захиалагч томилогдсон. 14 ажилд аймгийн БОАЖГ, БЗОСК ТӨААТҮГ, ГХБХБГ, Зуунмод сумын ЗДТГ тус тус 1 ажилд захиалагчаар томилогдож хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

*Б.2.3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хийгдсэн ажлуудаас хөрөнгө оруулалтын чанартай 4 ажилд БЗОСК ТӨААТҮГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Үүнээс түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжээгүй. Бүрэн суманд баригдсан нутгийн удирдлагын ордны барилга угсралтын ажлын хувьд зураг төсөл зохиогчоор “Тоонот констракшн” ХХК, гүйцэтгэгчээр Мета менежмент ХХК шалгарч гүйцэтгэсэн. Захиалагчийн зүгээс зураг төслийн ажлын даалгавар өгөхөөс эхлээд хяналт хэрэгжүүлсэн байна. Зураг төсөл зохиогчийн үе шатны ажлуудад хяналт тавьж дараах зөвлөмж үүрэг даалгавруудыг өгч ажилласан байна Үүнд:

- Барилгын тэг тэнхлэгийг шилжүүлсэнтэй холбоотойгоор барилгын буурь хөрсийг хуучин геологийн судалгаатай таарч байгаа талаар хөрсний хяналтын актаар баталгаажуулсан
- Барилга угсралтын ажилд ашиглагчийн саналаар 2-р давхар хучилтгүй задгай хэсгийг хучилттай болгох
- Барилгын заслын материалыг сонгохдоо захиалагч, зохиогч, ашиглагчтай заавал зөвшилцөх
- Барилгын гадна тохижилтын ажлыг дулааны улиралд багтаан батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийх
- Дээвэрт амьсгалуулагч хоолой хийх, налууг засах
- Дээврийн ус зайлуулах яндангийн төгсгөлийг 135 градусаар холбож усны хаялгын хэсгээс гадагш гаргах
- Гэрэлтдэг хаяг, гадна гэрэлтүүлэг хийх зэрэг.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж барилгын үе шатны ажлууд дээр газар дээр нь 8 удаа очиж холбогдох инженер техникийн ажилтнуудад үүрэг даалгавар өгч ажилласан байна. Захиалагчийн хяналтаар дараах ажлуудыг хийлгүүлжээ.

- Барилга угсралтын ажилд календарчилсан графикийг шинэчлэн батлуулах
- Суурийн ажил дээр зохиогчоос бетоны марк тодорхойлуулж баталгаажуулах
- Сантехникийн угсралтыг хийхдээ зургийн дагуу сантехникийн угсралтаар хийх
- Халаах хэрэгслүүдийг сонгохдоо зохиогчтой зөвшилцөх
- Цэвэр усны шугам угсралтыг шаардлагатай газруудад дулаалах
- Дээврийн ажлыг хийж гүйцэтгэхдээ налууг баталгаажуулан акт үйлдэх
- Ашигласан бараа материалын тохирлын гэрчилгээ сертификатыг ажлын талбай дээр бэлэн байлгах
- Барилгын гадна талбайг цэвэрлэх
- Дээвэрт гарах шатны бэхэлгээг сайжруулж засах
- Цонхны гадна усны хаялга төмрүүдийг гадагшлуулж засах

- Узелийн өрөөнд решотик байрлуулах
- Гадна бохир усны талбайг тэгшлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний тоноглолуудыг бүрэн хийх
- Камержуулалтыг бүрэн болгох
- Өрөөний гэрэлтүүлгийг гүйцээх
- Таних тэмдгүүдийг бүрэн байрлуулах

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын дээвэр, гадна засварын ажлын захиалагчаар ажиллаж, нийт 4 удаа үе шатны ажлууд дээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ. Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн дотор цахилгаан монтаж хийх ажлын явцад хариуцсан инженер удаа хяналт хийж тус ажлыг хүлээж авах комисст орж ажиллажээ.

Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн авто зам засварын ажлуудад БЗОСК ТӨААТҮГ захиалагчаар томилогдож хяналт хэрэгжүүлсэн. Зуунмод хотын авто замуудын дагуу явган хүний зам, хашлага засварын ажлын гүйцэтгэлийн явцад захиалагчийн зүгээс өдөр тутмын хяналт хийхийн хажуугаар ажил эхлэх бүрд /7 удаа/ зөвшөөрөл авах хүсэлт буюу рекуст авч баталгаажуулжээ. Аймгийн 1000 айлын орон сууцны хороолол доторх авто замын засварын ажилд өдөр тутмын хяналт тавьж 2 удаа зөвшөөрөл авах хүсэлт, усны аж ахуй хэсгийн авто замын ажлыг хийж гүйцэтгэхэд 9 удаагийн зөвшөөрөл авах хүсэлт авч баталгаажуулан ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна.

**Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар ямар нэг зөрчил илрүүлээгүй байна.**

Дээрх хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн зүгээс хийсэн хяналтаар тодорхой зөрчил илрүүлсэн, илэрсэн зөрчлийг арилгуулсан ямар нэг акт баримт байхгүй байна.

### **Б.3 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрэн олгосон байна.**

**Б.3.1. Үе шатны ажлын гүйцэтгэлийг захиалагч хянаж, баталгаажуулан санхүүжилтийн мэдэгдэл өгч санхүүжилт олгосон байна.**

Аймгийн шилжих үлдэгдлээр хэрэгжих 13 ажил, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 3,500.0 сая төгрөг батлагдсанаас 2,753.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс гүйцэтгэгчид 2,751.8 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 10.2 сая төгрөг, барьцаа санд 167.8 сая төгрөг, зураг төсөл зохиогчийн зардалд 3.3 сая төгрөг туст тус олгосон. Бүрэн сумын ЗДТГ-ын барилга, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын дээвэр, гадна засварын ажил, Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн цахилгаан засварын ажлуудаас холбогдох хуулийн дагуу барьцаа санд санхүүжилтээс суутган байршуулжээ. Мөн гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэн хүлээлгэж өгөөгүй аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид олголгүй 100 хувь, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтийн 50 хувийг барьцаа санд байршуулсан. Монбелиард үүлдрийн үхэр нийлүүлэх тендерт шалгарсан Нүүдэлчин агро ферм ХХК-д 2022 оны 6 дугаар сард багтаан үхрээ хүлээлгэн өгөх гэрээ байгуулж санхүүжилт 425.0 сая төгрөгийг бүрэн олгосон.

Замын сангийн хөрөнгөөр 2021 онд 682.0 сая төгрөгөөр 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 11 арга хэмжээ хэрэгжиж 596.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Гүйцэтгэгчид 575.9 сая төгрөг, 7-н ажлын захиалагчийн хяналтын зардалд 6.5 сая төгрөг олгож, 3-н ажлаас барьцаа санд 13.7 сая төгрөг төвлөрүүлсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 20 ажилд 752.5 сая төгрөг батлагдсанаас 678.1 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгчид 583.6 сая төгрөг, захиалагчийн зардалд 9.5 сая төгрөг олгож, барьцаа санд 85.0 сая төгрөг суутган төвлөрүүлсэн.

Санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгчээс гаргасан үе шатны ажлын гүйцэтгэлийн захиалагч хянаж, баталгаажуулан ЗДТГ-н ХОХБТХ-д ирүүлснийг үндэслэн СТСХ-д санхүүжилтийн мэдэгдэл өгч мөнгийг шилжүүлсэн байна.

*Б.3.2. Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудыг ашиглалтад хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгах ажил бүрэн хийгдээгүй байна.*

Аймгийн шилжих үлдэгдлээр хэрэгжсэн ажлуудаас Бүрэн сумын ЗДТГ-ын барилгыг тус байгууллагад 955.5 сая төгрөгөөр бүртгэсэн, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын дээвэр, гадна засварын ажил 52.2 сая төгрөг, Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн цахилгаан засварын 10.0 сая төгрөгийн ажлуудыг тухайн байгууллагуудад капиталжуулан бүртгэсэн байна. Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Угтаалцайдам, Эрдэнэ, Лүн сумдад шинэ хөдөө хөтөлбөрийн хүрээнд олгосон 28.2 сая төгрөгийн төлгөн, хурган хуцыг данс бүртгэлд бүртгээгүй байсныг тухайн сумдад нь бүртгүүлэх албан шаардлага бичигдсэн.

Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зам засварын ажил, зураг төслийн 434.0 сая төгрөгийн 7-н ажлыг ашиглагч байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөөгүй Зуунмод сумын ЗДТГ-д бүртгэлд бүртгээгүй байна. Аймгийн ОНӨГ-т замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглагч байгууллагыг тодорхой болгож данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичигдсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн сумын төвийн ундны усны худагт суурилуулсан ус зөөлрүүлэх төхөөрөмж, ус түгээх цахим төхөөрөмжийг Баянчандмань, Сүмбэр, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдын ЗДТГ, Төвчандмань ДЭХГ 56.2 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна. Лүн, Өндөрширээт, Бүрэн, Баянцогт, Баяндэлгэр, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Баянчандмань зэрэг 9 сумдад шинээр гаргасан худгийг 104.8 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн. Сумдад ногоон байгууламж байгуулах ажил Сэргэлэн, Эрдэнэсант, Бүрэн, Сүмбэр, Аргалант, Өндөрширээт, Дэлгэрхаан зэрэг сумдад хийгдсэнийг Бүрэн, Сүмбэрээс бусад сумд тус бүр 60.0 сая төгрөгөөр бүртгэсэн, бүртгээгүй 2 сумдад ажлыг гүйцээлгэн данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичигдсэн.

Мөн аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, олон улсын шинэ нисэх онгоцны буудал дахь "Аялал жуулчлалын мэдээллийн төв"-ийн тохижилт, Хэрлэн, Туул голын дагуу мод үржүүлгийн газар байгуулах зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулж, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажил, хог хаягдлыг ангилан ялгах, шатаах, ландфилл байгуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл зэрэг ажлыг аймгийн БОАЖГ-т бүртгүүлэхээр албан шаардлага өгсөн. Мөн ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ойгоос мод шилжүүлэн суулгах замаар аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 126.0 сая төгрөгийн ажил, шинээр хийсэн 10.0 сая төгрөгийн хогийн савыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгуулах албан шаардлага өгсөн.

#### **Б.4 Нийт 4 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.**

Өмнөх онд "Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг"-т хийсэн аудитаар Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ нарт

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэх заалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих,  
ОНӨГ-ын дарга Д.Батжаргалд
- Үнэлгээний хороодын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулж тендер шалгаруулалттай холбоотой илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өмнөх аудитудаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах
- Үнэлгээний хорооны маягтын бүрдэл, гарын үсэг, огноо баримт бичиг боловсруулалтад хяналт тавих гэсэн зөвлөмжүүдийг өгч хэрэгжилтийг гаргуулан авсан.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-н дарга Д.Саран-Эрдэнэ 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 07/1841 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж ирүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэх заалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих гэсэн зөвлөмжийн дагуу гэрээ шууд байгуулагдахаар шийдвэрлэсэн төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.2-д заасны дагуу цахим системээр гэрээ шууд байгуулах хэлэлцээрийг зохион байгуулж шалгарсан этгээдийн үр дүн, гэрээ гүйцэтгэлийг ил тод болгосон байна.

Аймгийн ОНӨГ-ын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 285 тоот албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд байгууллагын дотоодод 2019, 2020 онуудад зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын холбогдох материалд дүн шинжилгээ хийж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл, дүгнэлтийг хэлэлцсэн. Үүний хүрээнд ирэх жилийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахад алдааг засан, хуульд нийцүүлэх талаар шалгуур үзүүлэлтийг тогтоох, явцын хяналтыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна гэж ирүүлсэн.

Энэ аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой өмнөх жилүүдэд илэрч байсан зөрчлүүд эрс багссан нь зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авсантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөсөн ажлуудад сумдын ИТХ, Засаг даргын болон холбогдох байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг харгалзахаас бус иргэд, олон нийтийн санал авах талаар бодитой ажил хийгдээгүй байна.
- 2021 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийн хувьд хугацаандаа хэрэгжих боломжтойгоор санхүүжилт нь батлагдсан байна.
- Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлуудын худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулахгүй байх зөрчил давтан гарсаар байна.
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх нэг ажлын хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээний хороо байгуулахаар заасан хугацаанаас хойш эрх шилжүүлэх захирамж гарчээ
- Засгийн Газрын шинэ хөдөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 425.0 сая төгрөгөөр “Монбелиард” үүлдрийн үхэр нийлүүлэх тендер зарлаж тендерийн баримт бичгийн шалгуурыг хангаагүй байхад Нүүдэлчин агро ферм ХХК-г шалгаруулсан байна.
- 2021 онд хийгдсэн ихэнх ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна.
- Аймгийн шилжих үлдэгдэл, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн зарим ажлуудын ашиглагч байгууллагыг тодорхой болгож, шинээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах шаардлага байна.
- Өмнөх аудитаар өгөгдсөн 4 зөвлөмжийн 1 зөвлөмж хэрэгжээгүй, 3 зөвлөмж хэрэгжжээ.

### ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, ОНӨГ-ын дарга Д.Батжаргал нарт зөвлөх нь:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх,
- Сумдад эрх шилжүүлэх шийдвэр гаргахдаа төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлах
- Замын сангаар хэрэгжих зам засвар, арчлалтын ажлыг хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны журмаар гүйцэтгүүлэх

ХХААГ-ын Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Гантулгад зөвлөх нь:

- Засгийн Газрын шинэ хөдөө хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Монбелиард” үүлдрийн үхэр нийлүүлэх шаардлага хангасан хоршоо сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Аудитын менежер О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

417/14/522  
НЮУ 00064 0060464

### Холбогдох байгууллагын санал:



ТӨВ АЙМАГ  
БАРЦЛАГА ЗАХИЛАГЧ ОРОН СУУЦНЫ  
КОРПОРАЦИОНӨХААГУУ

41100 Төв аймаг | Зүүнбаян сум  
Утас: 70272840

2022.04.29

№

186

Танай

Тайлбар №

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ

Ж.БАТТӨГС

4122000312



ТӨВ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

41100 Төв аймаг, Зуунмод сум  
Утас 70273539, Факс 70273579

2022-04-29 № 105

Тайлан № \_\_\_\_\_

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улс орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлантай танилцсан бөгөөд зөвлөмжийг хойшид хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ

202205096



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70273290, Факс: 70272457  
Email: boaj\_tov@gmail.com, Цөхмөр хуудас: baigali.to.gov.mn


Аялал-04-29 № 07/1625  
төвний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан болно.

Гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлтэд тухайлан өгөх саналгүй болохыг мэдэгдэж байна.

ДАРГА



ЖЛАШ-ЯЙЧИЛ

4122030150



ТӨВ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41100 Төв аймаг - Төвмэг.сүм  
Утас: 70272262, Факс: 70272192

2022.04.26

№

07354

танай

оны №

-1

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ

2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгө  
оруулалтын аудитын тайлантай танилцлаа.  
Тайлангийн төсөлд өгөх саналгүй байна.

ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б НАСАНЖАРГАЛ

My doc: Toot A5



ТӨВ АЙМАГ  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

41111, Төв аймаг, Зүүнмод сум  
Утас: 70273092 Цахим шуудан: tuv\_bhaag@yahoo.com

2022.04.29 № 146  
танай -ны № -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлангийн дүгнэлттэй танилцлаа.  
Манай байгууллагаас өгөх санал байхгүй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТРӨГЧ Н.ГАНТУЛГА



07 202

ННА АГ: Alban Kichintoot AS



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР

4100 Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70271623, Факс: 70272237

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

2022.04.29 № 07/768

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын тайлангийн төсөлд  
санал өгөх тухай

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой манай хэлтсээс дараах тайлбарыг хүргүүлж, дүгнэлт зөвлөмжид харгалзан үзэхийг хүсэж байна. Үүнд:

Тайланд:

1 “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.4. Зам тээвэр, харилцаа холбоо гэсэн бүлгийн 201-д Батсүмбэр сумын Мандалын гүүрний шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ, 202-д гүүрний ээлжит засварын ажлыг эрэмбийн дагуу хийнэ гэж заасан байхад гүүр засвартай холбоотой нэг ч ажил төлөвлөгөөгүй. 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй Өндөрширээт сумын мэнгэтийн давааны засварын ажилд 20,0 сая төгрөг төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.”

-Батсүмбэр сумын Мандалын голын төмөр бетон гүүрний шинэчлэлийн ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтад 930,0 сая төгрөг төлөвлөгдөж Туулын далай гүүр ХХК шалгаран он дамжин хэрэгжиж байна. Мөнгөнморьт сумын Хэрлэн гол дээр бирвазын засварт 40,0 сая төгрөг төлөвлөж орон нутагт эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн. Мөн Алтанбулаг сумын Туул голын салааны гүүрийг эхлүүлэхээр 2021 онд 24,4 сая төгрөг төлөвлөсөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх нь тодорхой болсон тул орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэхийг зогсоосон.

2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар монгол тарвага сэргээн нутагшуулах зардал (Баянцагаан сум)-15.0 сая, Бэлчээрийн худаг таргах-108.0 сая, хогийн сав байршуулах зардал 10.0 сая зэрэг ажлууд 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 50 хувь буюу тал нь “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдаагүй байна.

“Хөгжлийн түүхээ - Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.1.5-д Ховор, нэн ховор ан амьтдыг тархац нутгаар нь хамгаалж, нөхөн үржүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулж, биологийн олон янз байдлын удмын санг хамгаалан, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэн, хомсглоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлнэ. 6.2.3-т Худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж, бэлчээр усжуулалтыг 77.6 хувьд хүргэнэ. 6.1.7-д Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах боловсруулах, шатаах үйлдвэр аймгийн төв болон боломжтой сумдад байгуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл, менежментийг сайжруулан,

4102020479

дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг стандартад нийцүүлж, нөхөн сэргээнэ. гэх мэт ..

Дүгнэлтэд:

2021 онд хийгдсэн ихэнх ажил гэрээнд хугацаандаа хэрэгжээгүй байна.

-Улс, орон даяар гарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын гэрээт ажлууд төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй нөхцөл үүссэн гэж нэмж оруулах саналтай.

Зөвлөмжид:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх.

-Энэ зөвлөмжийг худалдан авах ажиллагааг хариуцан ажилладаг байгууллага болох Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх саналтай.

Бусад дурдагдсан асуудлыг хүлээн зовшоорч үйл ажиллагаандаа сайжруулалт хийж ажиллах болно.



### **Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:**

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ, ГХБХБГ, ХХААГ, БЗОСК ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудад тайлангийн төслийг хүргүүлж санал авсан. ЗДТГ-ын ХОХБТХ-ээс бусад байгууллагууд тайлангийн төсөлд саналгүй гэдгээ бичгээр ирүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн саналын дагуу тайланд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- 2021 онд хийгдсэн ихэнх ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна гэж аудитын дүн дүгнэлтэд орууллаа.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжийг худалдан авах ажиллагааг хариуцдаг ОНӨГ-т хүргүүлэх саналтай байна гэсний дагуу Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, ОНӨГ-ын дарга Д.Батжаргал нарт гэж өөрчилсөн.

Бусад саналыг хүлээн авч тайланд оруулах боломжгүй гэж үзсэн.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70272287  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)